ДОРНОД АЙМГИЙН
БОЛОВСРОЛЫН
ГАЗАР

# ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2025

## ГАЗАРЗҮЙ Онлайн сорил-4

**4 сарын 26 12.00-13.20**

1. Мааньт уулаас Тарваган дахын овоо хүртэл ОХУ-тай хиллэх хилийн урт хэдэн км байдаг вэ? /1 оноо /

A. 1259 км B. 4673 км C. 2392 км D. 3546 км E. 8219 км

2. Дэлхийн өмнөд хагасын нутгуудад хамгийн богино өдөр хэдэн сарын хэдэнд болдог вэ? /1 оноо /

A. 12-р сарын 22
B. 6-р сарын 22
C. 9-р сарын 23
D. 3-р сарын 21
E. 2-р сарын 20

3. Нарны аймгийн гарагуудаас дагуулгүй гараг аль нь вэ? /1 оноо /

A. Ангараг B. Бархасбадь C. Санчир D. Далай ван E. Буд

4. 4. Хэрэглэгчийн шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг судлах, шинээр нэвтрүүлэх нь аж үйлдвэрийн аль хэв шинж вэ? /1 оноо /

A. Анхдагч
B. Хоёрдогч
C. Гуравдагч
D. Дөрөвдөгч
E. Тавдагч

5. Дэлхийн хамгийн гүн нуур аль нь вэ? /1 оноо /

A. Мичиган B. Каспи C. Байгаль D. Виктори E. Титикака

6.

6. Эдийн засгийн Зүүн бүсийн тулгуур төв болох Чойбалсан, Өндөрхаан хотуудыг ямар үсгүүдээр тэмдэглэсэн байна вэ? /1 оноо /




A. Чойбалсан - В, Өндөрхаан - Б
B. Чойбалсан - А, Өндөрхаан - Б
C. Чойбалсан - В, Өндөрхаан - А
D. Чойбалсан - Б, Өндөрхаан - В
E. Чойбалсан - А, Өндөрхаан - В

7.

Буддын шашны урсгал аль нь вэ? /1 оноо /

A. Үнэн алдартан
B. Иудей
C. Протестант
D. Шийт
E. Махаяна

8.

. Хүн амын экологийн чанарын үзүүлэлтэд аль ойлголт нь орох вэ? /1 оноо /

A. Эрүүл мэндийн түвшин
B. Хүрээлэн буй орчны байдал
C. Ажил эрхлэлт
D. Хүн амд ногдох орлого
E. Хэвлэлийн бүтээгдэхүүний хүртээмж

9.

..............................нь голын хөндий гуу жалганд үүсдэг. /1 оноо /

A. Хүрхрээ
B. Агуй
C. Хөндий
D. Булаг
E. Ай сав

10.

10. Газарзүйн зураг, график болон босоо зүсэлт дээр ямарваа нэгэн зүйлийн тэнцүү утгыг холбон зурсан шугам байдаг. Ижил өндрийг холбосон шугамыг..........................гэнэ. /1 оноо /

A. Изогипс
B. Изокол
C. Изобар
D. Изотерм
E. Изобат

**11.** Дараах зурагт Балтийн тэнгисийг аль тивд хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ? /1 оноо /




A. Ази тив, 8
B. Африк тив, 2
C. Европ тив, 6
D. Ази тив, 1
E. Австрали тив, 7

**12.** . Дараах цөлүүдээс аль нь Африкт байдаг вэ? /1 оноо /

A. Атакам
B. Калахар
C. Их элсэн цөл
D. Мохав
E. Такламакан

13. . Хойд мөсөн далайн ай савд хамаарагдах голуудыг сонгоно уу. /1 оноо /

A. Орхон, Шишгэд
B. Халх, Улз
C. Үенч, Хуримт
D. Онон, Байдраг
E. Онги, Таац

14. 14. Биет таваараас ялгаатай эдийн засгийн утгаараа бүтээгдэхүүн гэж ойлгогддог хүний үйл ажиллагааны янз бүрийн хэлбэрийг үйлчилгээ гэдэг. Сурч боловсорч байгаа нь .................юм. /1 оноо /

A. Санхүүгийн үйлчилгээ
B. Ажил хэргийн үйлчилгээ
C. Нийгмийн үйлчилгээ
D. Аж ахуйн үйлчилгээ
E. Хувь хүнд үзүүлэх үйлчилгээ

15. 15. 1000 – 2000 км-ийн өндрийг хамардаг. Энд ус төрөгч хий зонхилох бөгөөд хийн атомууд маш сийрэг тул тодорхой орон зайд байрладаггүй, асар их хурдтайгаар сүлжин хөдөлж байдаг. Энэ нь хийн мандлын аль үе давхарга вэ? /1 оноо /

A. Тропосфер
B. Стратосфер
C. Мезосфер
D. Термосфер
E. Экзосфер

16. . Бөөн, борооны бөөн үүлний хэлбэрүүд нь аль мандлын үүлний төрөлд багтах вэ? /1 оноо /

A. Дунд мандлын үүл
B. Босоо хөгжлийн үүл
C. Доод мандлын үүл
D. Хэвтээ хөгжлийн үүл
E. Дээд мандлын үүл

17. НҮБ-ын албан ёсны хэл аль нь вэ? /1 оноо /

A. Монгол
B. Норвег
C. Орос
D. Португал
E. Швед

18. 18. Хөдөө аж ахуйн эрчимжсэн, ашиг өндөртэй, дэлхийн ХАА-н бүтээгдэхүүний 60 хувийг үйлдвэрлэдэг орнууд алинд нь хамаарах вэ? /1 оноо /

A. Хөгжингүй орнууд
B. Далайд гарцтай орнууд
C. Хөгжиж буй орнууд
D. Өмнөд орон
E. Далайд гарцгүй орнууд

19. Зурагт 1-ийн тоогоор тэмдэглэсэн хэсэг нь гадаргын ямар хэлбэр вэ? /2 оноо /




A. Зөрөх хөдөлгөөний улмаас дээш өргөгдсөн горст
B. Атираат хөдөлгөөний улмаас доош суусан хотгор буюу синклиналь
C. Зөрөх хөдөлгөөний улмаас доош суусан грабен
D. Атираат хөдөлгөөний улмаас дээш өргөгдсөн гүдгэр буюу антиклиналь
E. Холдон салах хөдөлгөөний улмаас дээш өргөгдсөн хэсэг

20. Экваторын шугам ямар ямар эх газруудын хэсгийг дайран өнгөрөх вэ? /2 оноо /

A. Хойд Америк, Африк, Ази
B. Өмнөд Америк, Африк, Ази
C. Европ, Африк, Австрали
D. Ази, Австрали, Өмнөд Америк
E. Антарктид, Африк, Европ

21. Дараах зурагт Ярантайн боомтыг аль аймагт хэдийн тоогоор тэмдэглэсэн байна вэ? /2 оноо /




A. Дорноговь аймаг, 4
B. Сүхбаатар аймаг, 6
C. Өмнөговь аймаг, 2
D. Говь-Алтай аймаг, 3
E. Ховд аймаг, 1

22. . Хангайн нурууны ноён оргил аль нь вэ? /2 оноо /

A. Асралтхайрхан д.т.д 2800 м
B. Мөнхсарьдаг д.т.д 3491 м
C. Отгонтэнгэр д.т.д 4021 м
D. Хүйтэн уул д.т.д 4374 м
E. Халзан уул д.т.д 1503 м

23.

23. Дараах хотуудыг баруунаас зүүн тийш орших дарааллаар нь зөв бичсэн хувилбарыг сонгоно уу. /2 оноо /

1. Өндөрхаан
2. Зуунмод
3. Баруун-Урт
4. Улиастай
5. Арвайхээр

A. 4-3-1-2-5
B. 4-1-2-5-3
C. 4-5-1-2-3
D. 4-2-5-3-1
E. 4-5-2-1-3

24.

24. Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 5-аас дээш хувийг үйлдвэрлэж байгаа болон үйлдвэрлэх боломжтой ордуудыг стратегийн орд гэнэ. Дараах ордуудаас стратегийн ач холбогдол бүхий орд газар аль нь вэ? /2 оноо /

A. Чандгана тал нүүрсний орд
B. Цагаан дэлийн жоншны орд
C. Шивээ-Овоогийн нүүрсний орд
D. Хар тарвагатай нүүрсний орд
E. Толгойт алтны орд

25.

25. ОПЕК гэдэг нь газрын тос экспортлогч орнуудын холбоо юм. Энэ холбоонд Ази тивээс дараах улсуудын аль нь ордог вэ? /2 оноо /

A. Саудын Араб
B. Филиппин
C. Энэтхэг
D. Лаос
E. Мьянмар

26. Австралийн эх газрын хамгийн өндөр цэг, нам цэгийг зөв бичсэн хувилбарыг сонгоно уу. /2 оноо /

A. Мак-кинли 6194 м, Үхлийн хөндий -89 м
B. Килиманджаро 5879 м, Ассаль нуур -89 м
C. Косцюшко 2230 м, Эйр нуур -16 м
D. Килиманджаро 5879 м Вальдес хойг -40 м
E. Косцюшко 2230 м, Ассаль нуур -89 м

27. Гренланд арал ба Исланд арлууд ямар хоолойгоор тусгаарлагддаг вэ? /2 оноо /

A. Берингийн B. Дрейкийн C. Торресын D. Данийн E. Мозамбикийн

28. 28. Дараах зурагт газарзүйн тусгагийн ямар төрлийг үзүүлсэн байна вэ? /2 оноо /



A. Азимут тусгаг
B. Меркарторын тусгаг
C. Гүүдийн тусгаг
D. Робинсоны тусгаг
E. Синусоид тусгаг

29. . 1200 жилийн өмнө кофег анх аль улсаас нээсэн бэ? /2 оноо /

A. Норвег
B. Этиоп
C. Финлянд
D. Итали
E. Танзани

30. 30. Монгол Улсын бүх нутаг дэвсгэр нь газрын нэгдмэл санг бүрдүүлнэ. Газрын нэгдмэл сан үндсэн 6 ангилалд хуваагддаг ба дараах бүдүүвчийн цэгийн оронд тохирох хувилбарыг сонгоно уу. /2 оноо /




A. Усны сан, Дархан цаазат газар
B. Ойн сан, Байгалийн цогцолборт
C. Улсын тусгай хэрэгцээний газар, Ойн сан,
D. Зам, шугам сүлжээ, Дурсгалт газар
E. Цогцолборт газар, Нөөц газар

31.

1. Дараах улсуудаас Баруун Африкийн бүлэг улсуудыг сонгоно уу. /2 оноо /

A. Марокко, Түнис, Ливи
B. Кени, Этиоп, Сомали
C. Түнис, ӨАБНУ, Ливи
D. Нигер, Мали, Мавритан
E. Намиби, Ботсван, Танзани

32.

32. Зурагт 4-ийн тоогоор Түрк улсыг тэмдэглэжээ. Түрк улс нь ямар хойг дээр оршдог вэ? /2 оноо /




A. Аравын хойг
B. Перенейн хойг
C. Скандиновын хойг
D. Бага азийн хойг
E. Апеннинний хойг

33.

3. Нуур, тэнгисийн эрэг орчмоор үүсдэг эргээс нуур луу үлээдэг салхийг......................гэнэ. /2 оноо /

A. Өдрийн бриз
B. Зуны муссон
C. Шөнийн бриз
D. Өвлийн муссон
E. Пассат

34.

34. Г. Меркаллын 1902 онд боловсруулсан газар хөдлөлтийн хүчийг хэмжих I-XII балл шатлал нь газар хөдлөлтийн үед гадарга дээр үүсэх янз бүрийн шинж тэмдэгт тулгуурладаг бол **XI** баллын газар хөдлөлтийн үед ямар шинж тэмдэг илрэх вэ? /2 оноо /

A. Мэдрэгдэхгүй, зөвхөн багажинд бүртгэгдэнэ.
B. Гудамжинд мэдэгдэнэ, савнаас шингэн цалгина.
C. Гэр дотор мэдэгдэнэ, өлгүүртэй зүйлс савлана.
D. Цонхны шил харжигнана, сав суулга чахрана.
E. Бараг бүх чулуун байгууламж эвдэрнэ, хөрсний шилжилт үүснэ.

35.

. Дараах улсуудаас гадаргын усны импортоос хамаардаг улсууд аль нь вэ? /2 оноо /

A. Тайланд, Ботсван
B. Испани, Португал
C. Унгар, Иран
D. Мавритан, Гамби
E. Туркменистан, Тайланд

36. . Хүснэгтэд өгөгдсөн мэдээллийг зөв тохируулна уу. /2 оноо /

| Арлын нэр | дугаар | Далайн нэр | тэмдэглэгээ |
|---|---|---|---|
| Мальдив | 1 | Номхон | a |
| Галапагос | 2 | Хойд мөсөн | b |
| Куба | 3 | Энэтхэгийн | c |
| Шинэ Сибир | 4 | Атлантын | d |

A. 1c, 2b, 3d, 4a
B. 1a, 2d, 3c, 4b
C. 1d, 2a, 3b, 4c
D. 1c, 2a, 3d, 4b
E. 1c, 2b, 3a, 4d

37. . Газрын гадаргын үржил шим бүхий өнгөн хэсгийг хөрс гэнэ. Хөрс үүсэхэд аль нь нөлөөлөх вэ? /2 оноо /

A. Усжуулалт, хөрсний бүтэц
B. Эх чулуулаг, хөрсний өнгө
C. Уур амьсгал, организм
D. Газрын хотгор гүдгэр, агааржуулалт
E. Гадаргын байршил, хөрсний үе давхарга

38.

38. Австралийн холбооны улс нь нийт 8 муж улстай бөгөөд зурагт 7-ийн тоогоор тэмдэглэсэн мужийн төв нь Хобарт, нийт 68 401 км$^2$ нутагтай юм. Энэ мужийн нэрийг олно уу. /2 оноо /




A. Тасман
B. Шинэ өмнөд Уэльс
C. Квинсленд
D. Виктори
E. Баруун Австрали

39.

). “Их-7”-ийн орнуудад ордог Европ тивийн ерөнхийлөгчийн засаглалтай улс аль нь вэ? /2 оноо /

A. Герман
B. Их Британи
C. АНУ
D. Австрали
E. Канад

40.

. 2 цагийн хугацаанд дэлхий тэнхлэгээ хэдэн градусаар эргэх вэ? /2 оноо /

A. $60^0$  B. $75^0$  C. $45^0$  D. $90^0$  E. $30^0$

41. . Х.Ө $46^{0}$ 43/ З.У $119^{0}$ 56/ -ын солбицолд оршдог газарзүйн ямар объект байдаг вэ? /2 оноо /

A. Монгол шарын даваа- хойд захын цэг
B. Орвог гашууны бор толгой- өмнөд захын цэг
C. Соёлз уулын модтой хамар- зүүн захын цэг
D. Монгол алтайн Маанът уул- баруун захын цэг
E. Өвөрхөшөөтийн булаг- төв цэг

42. . Бэлчээрийг зохицуулалттай ашиглах аргуудаас холимог арга нь ..................онцлогтой юм. /2 оноо /

A. Тухайн бэлчээрт зөвхөн жилийн тодорхой хугацаанд мал бэлчээдэг
B. Малыг бэлчээрийн тогтоосон нэгжид өдрийн тэжээлийн хэрэгцээгээ ханган бэлчээдэг
C. Зэргэлдээ хоёр бэлчээрийг ээлжлэн ашиглан бэлчээдэг
D. Хоёр болон түүнээс дээш төрлийн малыг бэлчээрийн нэг хэсэгт хамт бэлчээдэг
E. Бэлчээр талхлагдан хөрс доройтохоос сэргийлэхийн тулд богино хугацаанд бэлчээдэг

43. 43. Аз жаргалын индекс дараах 3 үзүүлэлтийг дундажлан авч үздэг бөгөөд асуултын тэмдгийн оронд орхигдсон ойлголтыг олно уу. /2 оноо /




A. Үндэсний нийт орлого
B. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн
C. Хүн амын дундаж наслалт
D. Хүн амын өсөлтийн түвшин
E. Бичиг үсэг тайлагдсан байдал

44.

44. 1:15 000 000 –ын тоон масштабыг нэрлэсэн масштаб болгон бичсэн зөв хувилбарыг сонгоно уу. /2 оноо /

A. 1 см-т 150 км
B. 1 см-т 1500 км
C. 1 см-т 15000 км
D. 1 см-т 150 м
E. 1 см-т 1500 м

45.

45. Микронези, Соломон арлууд оршдог энэ бүс нутаг нь 1960- аад оноос худалдаа, аж үйлдвэрийн салбар эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд төмрийн хүдэр, чулуун нүүрс, хөнгөн цагаан, тугалга, байгалийн хий, уран, никель, титан, алт, алмазын арвин нөөцтэй. Энд ямар бүс нутгийг дурьдаж байна вэ? /2 оноо /

A. Хойд Африк ба Баруун өмнөд ази
B. Хойд Америк
C. Зүүн өмнөд Ази ба Номхон далайн өмнөд хэсэг
D. ОХУ ба хөрш зэргэлдээ орнууд
E. Зүүн Ази

46.

46. Дэлхийн гадаад буюу экзоген хүч нь нарны энерги ба хүндийн хүчний нөлөөгөөр үүснэ. Асуултын тэмдгийн оронд аль нь тохирох вэ? /2 оноо /




A. Тектоник хөдөлгөөн
B. Газар хөдлөлт
C. Галт уулшил
D. Цунами
E. Усны үйл ажиллагаа

47.

47. Хөгжиж буй орнуудын хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөнд нөлөөлдөг *түлхэгч* гол хүчин зүйл аль нь вэ? /2 оноо /

A. Зай завгүй байдал
B. Эрчим хүч, усан хангамжийн дутагдал
C. Чимээ шуугиантай орчин
D. Өндөр өртөг зардал
E. Тайван амьдралын хэв маяг

48. . Хүснэгтэд өгөгдсөн мэдээллийг зөв тохируулна уу. /2 оноо /

| ТХГН-ийн нэр | Ангилал |
|---|---|
| 1. Цамбагарав уул | a. Дурсгалт газар |
| 2. Увс нуурын ай сав | b. Байгалийн нөөц газар |
| 3. Бурханбуудай | c. Байгалийн цогцолборт газар |
| 4. Хөргийн хөндий | d. Дархан  цаазат газар |

A. 1c, 2b, 3a, 4d
B. 1c, 2a, 3d, 4b
C. 1c, 2a, 3b, 4d
D. 1c, 2d, 3b, 4a
E. 1c, 2b, 3d, 4a

49. 49. Үндэстэн дамнасан корпораци гэдэг нь олон оронд салбартай томоохон компанийг хэлнэ. Тэгвэл АНУ-ын ҮДК болох Nestle –н төрөлжилт аль нь  бэ? /2 оноо /

A. Машин
B. Хүнс
C. Түргэн хоол
D. Хувцас
E. Ундаа

50. Улсуудын нэрийг нийслэл хоттой нь зөв харгалзуулна уу. /4 оноо /

1) Египет
2) Ливи
3) Тайланд
4) Туркменистан

a) Триполи
b) Бангкок
c) Ашхабад
d) Кайр

A. 1d, 2a, 3b, 4c
B. 1b, 2d, 3c, 4a
C. 1d, 2a, 3c, 4b
D. 1b, 2d, 3c, 4a
E. 1d, 2c, 3a, 4b

2.1. 2.1 Монголд зун ирсэн Канадын жуулчинд өнөөдөр агаарын температур $25^0$ С гэдгийг Франгейтын хуваариар хэд гэж ойлгуулах вэ?

2.2. 2.2 Бразил улсын хүн ам 2012 онд 197 сая, дундаж өсөлт 1.2% бол хүн амын тоо хэдэн жилийн дараа 2 дахин нэмэгдэх вэ?

2.1. 2.3 1:200 000 масштаб бүхий газарзүйн зурагт тэгш өнцөгт хэлбэртэй ногооны талбай 2x4 см хэмжээтэй зурагдсан бол ногооны талбайн бодит зайг бодож олоорой.

2.1. 2.4 Чойбалсан хот Х.Ө $48^0$ $04^/$ З.У $114^0$ $30^/$ оршдог. Тэгвэл экватор дээр нар эгц тусаж байхад үдийн нарны өндөр хэдэн градус, хэдэн минут байхыг бодож олно уу.

| № | D | |
|---|---|---|
| | Зөв хариу | Оноо |
| 1 | D | 1 |
| 2 | B | 1 |
| 3 | E | 1 |
| 4 | D | 1 |
| 5 | C | 1 |
| 6 | C | 1 |
| 7 | E | 1 |
| 8 | B | 1 |
| 9 | D | 1 |
| 10 | A | 1 |
| 11 | C | 1 |
| 12 | B | 1 |
| 13 | A | 1 |
| 14 | C | 1 |
| 15 | E | 1 |
| 16 | B | 1 |
| 17 | C | 1 |
| 18 | A | 1 |
| 19 | C | 2 |
| 20 | B | 2 |
| 21 | E | 2 |
| 22 | C | 2 |
| 23 | E | 2 |
| 24 | C | 2 |
| 25 | A | 2 |
| 26 | C | 2 |
| 27 | D | 2 |
| 28 | E | 2 |
| 29 | B | 2 |
| 30 | C | 2 |
| 31 | D | 2 |
| 32 | D | 2 |
| 33 | C | 2 |
| 34 | E | 2 |
| 35 | D | 2 |
| 36 | D | 2 |
| 37 | C | 2 |
| 38 | A | 2 |
| 39 | A | 2 |
| 40 | E | 2 |
| 41 | C | 2 |
| 42 | D | 2 |
| 43 | C | 2 |
| 44 | A | 2 |
| 45 | C | 2 |
| 46 | E | 2 |
| 47 | B | 2 |
| 48 | D | 2 |
| 49 | B | 2 |
| 50 | A | 4 |
| 2.1 | a7b7 | 4 |
| 2.2 | a5b8cd3 | 4 |
| 2.3 | a3b2 | 4 |
| 2.4 | a4b1c5d6 | 4 |